

СОЛОНГОСТ МОНГОЛЫН АРМИ АНХ ОРСОН ТҮҮХИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Ж.Баттөр*

Арвангурав дугаар зуунд Монголын зүгээс Солонгост хийсэн довтолгоо, явуулсан аян дайн болон 13, 14-р зууны үеийн Монгол Солонгос хоёр орны харилцаа, энэхүү харилцааны түүхэн болоод олон талт шинжийнх нь талаар хэдийгээр гадаад, дотоодын зарим эрдэмтэд судалгаа хийсэн ч энэ бүхнийг бүхэлд нь цогц байдлаар судлах шаардлага хэвээр байгаа юм. Ингэж бүхэлд нь цогц судалгаа хийхгүйгээр Солонгост явуулсан Монголын байлдан дагуулал, тэнд тогтоосон Монголын засаглал хийгээд тэр цаг үеийн хоёр орны харилцааны нарийн ширийнийг гүйцэд мэдэхэд амаргүй байгаа билээ.

Тухайн үеийн хоёр орны харилцааны түүхийн тулгуур сурвалж бичиг нь “Горие-са” буюу “Горие улсын түүх” мөн. Энэ бүтээлээс гадна “Юань ши” болон “Юань Гаоли жиши” зэрэг хятад түүхчдийн бүтээлийг дурдах ёстой болов уу. “Горие-гийн түүх” буюу “Горие-са”-г найруулан бичих ажил ихээхэн адармаатай замналыг туулсан байдаг. Анхны түүх бичлэг нь угтаа Солонгост 1395 оны эхний сард эхэлсэн байна. Энэ ажлыг Чүн Тожонь болон Чөн чөн нар удирдан хэрэгжүүлсэн бөгөөд уг ажлын үр дүнд “Горие Гүгса” буюу “Гориөгийн төрийн түүх” хэмээх 37 ботиос (гвөнъ) бүрдэх он дарааллын түүхэн бичиг бэлэн болсон ч харамсалтай нь хөл үймээнд үрэгдэж бидний үед ирээгүй юм. Гориө улс мөхсөний дараа Солонгост Жосөнъ улс байгуулагдсан. (1392-1910 он) Жосөний түүхэнд улс орондоо ихээхэн зүйл бүтээн алдаршсан гэгдэн одоо ч солонгосчуудын хүндэтгэлийг хүлээдэг “Сьежон Дэван” буюу Сьежон их хаан бол өнөөгийн Солонгосын үсэг болох хангыл үсэг зохиолцож, шинжлэх ухааны олон нээлт хийхэд гар бие оролцсон хаан юм. Энэ хааны шууд удирдлага, хүчин чармайлтаар хэд хэдэн оролдлогын эцэст “Гориө са”-г туурвин дуусгасан байна. Хэд хэдэн оролдлогын эцэст гэдэг нь Сьежон хааны 3-р онд Ю Гуань болон Пиөнъ Гиеран нар хамтран шүүн

* МУИС, ОУХС-ийн багш, доктор (Ph.D)

редакторлаж “Согьё Гориё-са” (Сурвалж баримтуудын харьцуулсан) Гориё-са бичиж байсан ч эцэслэн гараагүй, мөн 1438 онд Гуан че, Шинь Гэ нар Ян Сонжи-гийн удирдлагаар туурвиж, металл хэвлэлээр хэвлэсэн ч дээрээс батламжлалгүй байсаар зогссон байна. 1449 онд Сьежон хаан тухайн үед байсан “Шиллог” буюу “Магад тэмдэглэл”-үүдийг ашиглан “Чүн Чугуань” буюу “Түүх бичих товчоо”-ны эрдэмтдээр бичүүлэх гэсэн ч бичлэгийн арга зүйн үзэл баримтлалаасаа болж санал зөрөлдөцгөөсөн байна. Өөрөөр хэлбэл нэг хэсэг түүхчид он дарааллын арга зүйгээр бичих гэсэн бол нөгөө хэсэг нь шаштир-намтрын арга зүйг баримталж байв. Ингээд аль аль тал зэрэг бичиж эхэлсэн байдаг. Гэвч яваандаа шашдир-намтарын аргагүйгээр бичих болж бичиж дуусгасан туурвилаа И Мүнжон хааны эхний онд хаандаа өргөн барьсан ажгуу. Энэхүү хувилбарыг Ким Чондан, Чөн Инжи нар удирдсан агаад Чөн Инжи эцэслэн хаандаа өргөсөн байна. Бүтцийн хувьд нийт 139 гвонь буюу боть бөгөөд үүнээс 46 нь шаштир, 39 нь сэдэвчилсэн бичлэг, он дарааллын хүснэг 2 боть, намтар 50 боть, товъёог 2 боть болсон байдаг.

Солонгос улс Монголын эзэнт гүрний вассал улс болохоос өмнө тэр цаг үед хүчирхэгжиж байсан Хятадын Сөн (960-1126), Хятань буюу Ляо улс (907-1125), Жинь (1115-1234) болон Юань (1215-1368), Хятадын Мин (1368-1644) улмаар манж Чин улс зэрэг олон гүрэн улсын вассал, дагуул, түшмэг улс байсан бөгөөд одоо ч хойд Солонгос БНХАУ-ын улс төр, эдийн засгийн ихээхэн нөлөөлөлд байдаг. Тийм учраас Солонгос улс өнөөг хүртэл гадаад хүчин зүйлийн хэт их нөлөөнд орсон хэвээр байгааг харж болно. Нөгөө талаар дээрх харь улсуудын зүгээс байнгын довтолгоонд нэрвэгдэж байсан юм. Ерөөс Солонгос улс түүхэндээ харийн 900-1000 гаран удаагийн довтолгоонд нэрвэгдэж байсан¹ гэх бөгөөд энэ нь солонгос хүнийг ихээхэн үндсэрхэг үзэлтэй болгож, энэ нь эдийн засгаа хөгжүүлэхэд үзэл суртлын талаар эх оронч үзлийг нь эергээр ашиглахад төдийгүй, олдсон боломжийг алдалгүй дээд зэргээр ашиглахыг хичээдэг, аливаа зүйлийг түргэн шуурхай хийдэг зан суртахуунтай болоход нь нөлөөлжээ. Ийнхүү умард зүгээс ирсэн довтолгоо дарамтанд Гориёгийн үед монголчуудын довтолгоо багтаж байгаа юм. Тиймээс бусад үеүдийн адил Гориёгийн үеийн Монголын довтолгоог Солонгосын нийгмийн ерөнхий хөгжлийн чиг урсгалд хэрхэн нөлөөлөв гэдэг нь цаашдаа судлах шаардлагатай сэдэв юм. АНУ-ын судлаач Дон Обердорферийн бичсэнээр Солонгос үндэстэн түүхэндээ таван их гүрэн буюу Хятад, Монгол, Япон, АНУ, ЗХУ гэсэн таван

улсын колони, зарим үед бүрэн нөлөөнд нь орж байсан бөгөөд одоо ч зарим нэгнийх нь нөлөөнд байгаа юм² гэжээ.

Ерөөсөө ийнхүү байнгын довтолгоонуудыг судлаад Солонгосын түүхч И Пиендо “Гориё улсын түүх бол голлон умард хилээсээ хойшхи ард түмнүүдтэй харилцсан түүх гэж хэлж болно” хэмээн дүнэсэн байдаг.³ Тиймээс Монголын довтолгоонуудыг оролцуулаад харийн ард түмнүүдийн довтолгоо, өндөр хөгжсөн далайн худалдаа, Ялу болон Түмэн мөрний эх өөд тэлсэн аажим тэлэлт зэрэг Гориёгийн нийт түүхтэй холбогдох ба тэдгээр нь дотоодын хөгжлийнх нь суурь дэвсгэр, түлхэц болсон байна.⁴ Солонгосын түүхийн номноо Монголын довтолгооны шалтгааныг “Хятадын Алтан улс, өмнөд Сөн улс руу ээлж дараалан довтолгоо тэрхүү байлдааны ажиллагааны нэгэн хэсэг болгон Гориё рүү довтолжээ” гэж үзсэн байдаг.⁵ Мөн “Солонгосын түүхийн шилдэг сурах бичгийн нэг” гэж олон улсад үнэлэгддэг “Солонгосын эрт эдүүгээгийн түүх” номноо “Газар тариалан эрхэлдэг суурьшмал үндэстнүүдийн үйлдвэрлэж байсан баялаг нь угаасаа умардын нүүдэлчдийн эрхэндээ оруулах зөнг (acquisitive instincts) хөдөлгөдөг байсан бөгөөд тийнхүү Чинь, Сөн эзэнт гүрнүүд болон Гориё ч мөн адил Монголын довтолгооны гол бай нь (prime targets) болсон юм” гэжээ.⁶ Эдгээр үзэл дээр тулгуурлаад Гориёгийн түүхийг дотор нь гурван том хэсэгт багцлан хувааж болно. Үүнд:

Гориё улс байгуулагдсан 918 оноос 1170 он хүртэл. Энэ хугацаанд Солонгос орон хаан гэсэн нэг хүний төвлөрсөн засаглалтай орон байв.

1170-1270 он хүртэл. Энэ хугацаанд Солонгос цэргийн эрх мэдэлтний гарт бүрнээ орж ихээхэн хямарсан бөгөөд хаан нь зөвхөн бэлгэдлийн чанартай болж хүч нөлөөг цэргийн засаглал атгаж байсан. Цэргийн засаглалын уналттай хамт Монголын довтолгоо 1270 онд бүрэн зогсч, Монголын вассал улс болсноо бодит байдал дээр хэрэгжүүлсэн болно.

1270 оноос эхлээд Гориё улс мөхсөн 1392 он хүртэл. Энэ хугацаанд Гориёд Юань улсын ноёрхол тогтон бэхжиж яваандаа Юань улс мөхөх хэрээр Гориё ч сулран доройтсоор Мин улс мандасны дараа удалгүй Гориё мөхөж, Жосонь улс мандсан юм.

“Гориё-са”-д тэмдэглэснээр Гориё Монголын хоорондын анхны учрал Гориёгийн Хыйжон хааны 7-р онд буюу 1211 онд тохиожээ. Тэр үед Гориёгоос Жинь улсын ордон руу явж байсан элчийг монгол цэргүүд барьж аваад хороосон байна.⁷ Харин хятад хэлээр бичсэн 13,14-р зууны хоёр харилцааг судлахад чухал байр суурь эзэлдэг “Юань Гаоли

жиши” (Юань Гориө-гийн хэргийн тэмдэглэл) хэмээх судрын эхэнд Юань болон Гориө улс хэрхэн харилцаж эхэлсэн тухайд дараах маягаар өгүүлсэн:

Тайзу (Чингис хааныг хэлж байна. Ж.Б)-гийн 13 дахь онд (1218 он) тэнгэрийн цэргүүд Гориөд хүрэв (Тэнгэр гэдэг нь Монголыг хэлж байгаа юм). Тэдний (ө.х. Гориөгийн) хаан дагаар орж, харилцан элч илгээн жил бүр алба бария гэв. Арван есдөх жил (1224 он) дээрэмчид манай элчийг хороосноос хойш элч нар ирэхээ больсон юм” гэсэн байна.⁸

Ийнхүү өргөн хэмжээний харилцаа 1218 оноос эхэлжээ. Монгол Солонгосын харилцаанд Гориөгийн талд гарсан цаг төрийн хувиралт өөрчлөлтийг гурван томоохон хэсэгт хувааж болох юм:

- 1232 онд нийслэл болон засгийн газраа Гэгиөн (Гэсөн)-өөс Канхуа арал руу нүүлгэн шилжүүлсэн.
- 1258 онд Чой-гийн цэрэгжсэн хүчирхэг овгийнхныг төрийн эрхээс зайлуулсан.
- 1269 онд нийслэлээ Канхуа арлаас Гэсөн рүү буцаан нүүлгэж Воньжон хааны эрх мэдлийг сэргээсэн.

Эдгээрийг товчилбол Монголын довтолгооныг цэргийн хүчээр эсэргүүцсэн, дуртай дургүй хамтран ажиллах болсон хийгээд идэвхтэй холбоотон болсон гэж гурван үе болгон ангилж болно.

Харин Монголын талыг томоохон хэмжээнд 2 хэсэгт хувааж болох юм:

- Их Монгол улсын үеийн харилцаа
- Юань улс Гориөгийн харилцаа

Монголын талаас Гориө улс руу нийтдээ зургаан удаагийн цэргийн довтолгоон хийсэн юм. Эл жижиг өгүүллийн хэмжээнд бүгдийг нь нэгбүрчлэн нарийвчлан үзэх аргагүй тул Монголын талаас анх хэрхэн Гориөтой харилцаж эхэлсэн тухай товч атугай тодруулах зорилт тавьсан болно.

1218 оны өвөл Монголын цэргийн жанжин Хачин (Энэ хүний цэргийн цолыг “юаньшуай” гэсэн байна. Зарим номонд энэ цолыг “маршал” гэж орчуулснаас үзвэл цэргийн их өндөр цол бололтой. Маршалыг монголчууд “өрлөг жанжин” гэж буулгадаг) болон түүний туслах Чала нарын командласан нэг түмэн цэрэг, Ваньзиэн Зү юаний командалсан зүүн Зүрчидийн хоёр түмэн цэргийн хамт Их Монгол улсад дагаар орохгүй хэмээн урван дутаасан хятаньчуудыг хөөсөөр Солонгос руу цөмрөн орсон байдаг. Тэр үед

Хятаний арми Солонгосын Хуажү, Мэнжү, Сүнжү, Дөгжү хотуудыг эзлэн талж, тэндээ бүгсэн байжээ. Тэднийг элдсээр Монгол Зүрчидийн хамтарсан арми Гандон хэмээх сайтар хамгаалалт бүхий хэрэм цайзат хотод оруулсан байна. Энэ цайзат хот ч Хятаний бүгсэн сүүлчийн том түшиц болов. Монголчууд Хятаний эсрэг гурван жил тулалдсаар үндсэндээ бут цохиод байсан бөгөөд гол хүч нь ийнхүү дутаасаар Солонгост орж ирээд бүгээд байжээ. Уг Гандон хот нэгд ихээхэн бэхлэлтэй, хоёрт цас их орсоор зам боогдсон нь монголчуудын ахих замд давхар саад болсон ажгуу.

Хачин, Чала нар иймд Гандон орох замыг таслан хаахын тулд Гориөгийн “Баруун хойд хилийн тойрог”-ийн командлагч Чо Чүн генералд хандан тусламж хүсчээ. Ингээд орчуулагч болоод арван хоёр хүнтэй Монголын төлөөлөгчид Солонгосын дээрх командлагчид дараах зүйлсийг уламжилсан байна. Товч дурдвал: “Тэднийг Чингис хаан өөрөө Хятаныг дар гэж илгээсэн. Хятаньчууд танай Солонгос орныг гурван жил түйвээж байгаа. Бид цэрэг цуух болон хүнс зэргийг хүсч байна. Чингис хаан тэднийг илгээхдээ Хятанийг дарсны дараа Монгол Гориө хоёрыг ахан дүүгийн барилдлагатай болохыг хүссэн” гэсэн агуулгатай зүйлсийг хэлүүлжээ.⁹ Эндээс үзвэл Монгол-Гориөгийн ах дүүгийн холбоотны гэрээг (солонгосоор “Хиөнжье Мэн-яг”) байгуулахыг анхлан Чингис хаан даалгасан нь харагдаж байгаа юм. Өмнөд Солонгосын түүхч Го Биён-иг ч бас ийм дүгнэлт хийсэн.¹⁰

Энэ мэдээг авсан Солонгосын хааны ордон удтал хэлэлцэв. Энэ үед Солонгосын нэгэн цэргийн эрхтэн Ким Чириө ингэж анхааруулсан байдаг. “Нарийвчлан тунгаавал энэ өдөр манай улс үндэстний алдах онох нь шийдэгдэх нь. Хэрвээ бид тэднийг (ө.х. монголчуудыг) үл хүндэтгэн үзвээс бид хожим нь харамсан амаа барих болно гэдэгт би эргэлзэхгүй байна” гэсэн байдаг.¹¹ Ингээд Гориөгийн тал Монголчуудын хүсэлт шаардлагыг бүрэн хүлээн авч шилдэг мянган цэрэг, мянган сөг (“сөг” гэдэг нь Солонгосын хэмжээний нэгж бөгөөд барагцаалбал томоохон шуудайны хэрийн хэмжээ) тутрагатай Монголын ауругт (Монголын цэргийн хуаран, буудалласан газар, цэргийн тойрог Ж. Б.) хүрчээ. Солонгосын удирдагчид өөрсдийн хүмүүст монголчуудын байр байдлыг тандуулах давхар даалгавар өгчээ. Тэр үед Солонгосын Тэжү хэрмэнд бүгсэн хятаньчууд руу довтолгоон өрнүүлж байсан монголчууд тэднийг хөгжим дуугарган угтсан гэж тэмдэглэснээс үзвэл ихээхэн найрсгаар хүлээн авсан бололтой. Ингээд Солонгосын цэргийн командлагчийг монголчууд асартаа урин хүндэтгэлийн суудалдаа суулгажээ (баруун талын болон хоймрын суудлыг хэлж байгаа бололтой. Ж. Б.)¹².

Улмаар монгол солонгос цэргүүд бие биедээ ур чадвараа үзүүлсэн байна. Монгол дайчдын дундаас 46 цэрэг гарч ирээд гардан тулааны ур чадвараа сонирхуулсан бол Солонгосын талаас 20 мэргэн харваач гарч ирэн хятаньчууд руу зэрэг харван үзүүлсэн ажээ. Хачин түүнд:

“Манай үндэстнүүд ах дүү улс болох ёстой. Хэрвээ чи үүнийг хаандаа мэдэгдээд гэрээний захидалтай ирэх юм бол би түүнийг чинь өөрийн Эзэн хаандаа өргөн барих болно” гэсэн байна.¹³

“Юань ши”-д мөн энэ тухай гарах бөгөөд тэнд өгүүлэхдээ “Монгол Гориөгийн цэргийн командлагч Чала, Чо хоёр ах дүүгийн улс болохоор тохиролцов. Чо Монголын талаас жил бүрийн татвараас хэлтрүүлэхийг хүсэв. Чала хэлрүүн: Танай улсад хүрэх зам хол, ирж очих нь хүнд хүчир учраас жил бүр бид 10 элч илгээж алба авч явж байя гэв”¹⁴

Хятанчуудын орогнон бөгсөн Гандон хэрэмт хотын нэг талд 10 чүг өргөн, 10 чүг гүн нүх ухаад үлдсэн гурван талыг нь Монгол, зүүн Зүрчидийн цэргүүд, Гориөгийн арми тус тус бүслэв. Довтолгоон ширүүсэх тусам дөчин хятань хүн гарч ирэн буун өгчээ. Хятаньчуудын удирдагч Хаше өөрийгөө дүүжлэв. Улмаар цэрэг, эмэгтэйчүүд, албат нийлсэн 50 мянган хүн хэрмийн дааман хаалгыг нээн гарч ирэн буун өгч дагаар оржээ. Монголчууд Хятаний ханхүүгийн эхнэр Си болон 100 гаруй томоохон түшмэдийг тэр даруй хороогоод үлдсэн олон хүнийг цэргүүд олзлон харгалзжээ. Хачин Гориөгийн цэргийн командлагч нарт хэлэхдээ:

“Бид 10 мянган бээр газраас ирж та бүхэнтэй цэргийн хамтарсан хүчээр дээрэмчдийг бут ниргэлээ. Энэ бол мянган жилийн аз завшаан болой. Бид танай хаан дээр очиж мэндчилэн ёсломоор байвч арми маань ихээхэн том бас явах зам хол цөлх. Тиймээс би зүгээр л элч илгээн хаанд тань талархлаа өргөсү” гэжээ. Тулалдаан дууссаны дараа Монголын командлагчид Гориөгийн удирдагчид доорх алдартай хүсэлтийг тавьжээ:

“Манай хоёр үндэстэн үүрд ахан дүүс байх болтугай. Түмэн үеийн үр хойчис маань энэ өдрийг бүү умартаг.”¹⁵

Хариуд нь Солонгосын өрлөг жанжин Чо монголчуудад зориулж найр хийсэн байна. Хачин Гориөгийн талд Хятаний 700 эмэгтэй болоод идэр хөвгүүдийг өгч Хятаньд олзлогдоод байсан Гориөгийн 200 иргэнийг нь суллан буцаан өгчээ. Улмаар Хачин Чо, Ким хоёрт монгол тооны бэлгэдлээр ес есөн царайлаг охин, ес есөн аргамаг хурдан хүлэг бэлэглэсэн ажгуу.¹⁶ Үлдсэн Хятань олзлогсдыг монголчууд авч яваад өнөөгийн Өвөр Монголын нутагт тархаан байрлуулж, түүнээс хойш ч хятанчуудын нэр төдийлөн

дуулдахаа больсон билээ. Харин Гориёд олзлогдсон хятаньчуудыг Чо жанжин муж, нутгуудад хуваан өгч, атар газар олгон суурьшуулж, газар тариалан эрхлүүлжээ. Солонгосчууд тэдгээр нутгийг "Хятань суурин" гэж нэрлэх болсон байна.¹⁷

Гандонийг чөлөөлсний дараа Гориө Чала-гийн цэргийн төв бааз руу төлөөлөгчдөө илгээн энхийг хүссэн санал дэвшүүлсэн.¹⁸

Гориөгийн зүгээс мөн Монголын цэргийн командлагчдад бэлэг илгээн албан захидал хүргүүлэв. Тэрхүү бичгийн агуулга нь мөн "Гориө са"-д хадгалагдан үлдсэн. Утгачлан орчуулбал дараах мэт:

"Хаврын эхний энэ цагт бид та бүхний амар мэндийг хичээнгүйлэн эрье. Манай улс үндэстэн удаан хугацааны туршид Хятаний түрэмгийлэлд өртөж, энэ зовлогоос бид өөрснөө ангижирч чадахгүй байлаа. Харин тэгтэл манай өчүүхэн улсын төлөө эрхэм хүндэт өрлөг жанжин та алс холоос шударгуу цэргийн хамт морилон ирээд хээр талын нар болоод шүүдэрт гарав. Манай өчүүхэн улс танай цэргүүдийн туулсан хүнд бэрхийг санаж өчүүхэн бэлэг яаравчлан илгээсэн юм.

Эхэндээ Танай их армийн хилээр нэвтрэн орж ирэх өдрийг бид мэдээгүй бөгөөд бас дээр нь Хятаний дээрэмчид зам хөндөлсөн хаасан билээ. Тиймээс бид удаашран хөрш лүгээ цагт нь очсонгүй. Үүнийг бид туйлаас ёсгүй хэрэг гэж үзэн ихээхэн ичиж та бүхнийг биднийг уужим сэтгэлээр уучилна гэж найдаж байна.

Бид дөнгөж л Хятаний дээрэмчид өөрсдийгөө хамгаалахаар хэрэмт хот Гандоньд айсч орсныг сонсоод эд бол хэдийнээ шорон гянданд байх өчүүхэн амьтас гэж үзэн үл тоосон болой. Тэгээд бид талархал дэвшүүлэн та бүхний мэндийг асуух хүмүүс илгээсэн. Эдгээр элч нар маань замдаа хөдөлж ч амжаагүй байтал дээрэмчид хот балгадыг орхиод буун өгч, бүх улс үндэстэн маань бүгд баясан цэнгэж магнай тэнийв. Энэ бол их гүрэн сайнаар жижиг буурай улсад туслан хөрш орноо өрөвдөхийн үнэнхүү жишээ, түмэн үеийнхэнд нэг л тохиох аз завшаан бус уу. Бид та бүхний агуу өгөөмөрт сэтгэл догдлоод үүнийгээ яаж илэрхийлэхээ мэдэхгүй нь. Эдүгээ хааны зарлигийг даган бид бага сага тааруу дарс жимс бусад бэлгүүдийг бэлдэн тусгайлан түшмэд илгээн та бүхний таалалд хүргэж байнам. Эдгээрийн тоо хэмжээг тусад нь цаасан дээр бичсэн байгаа. Эдгээрийг авахаас бүү цааргалаач, бас биднийг дэндүү оройтуулсан гэж бүү шийтгээч.

Айн чичирч энэ бичгийг өргөн бария" гэжээ.

Монголын тал бэлэг болон захидлыг аваад хэдэн хоногийн дараа Пулитайе гэдэг элчийг Гоиөгийн нийслэл Гэгиөн рүү илгээсэн байна.¹⁹ Энэ бол яах аргагүй өмнө хоёр

орны төлөөлөгчдийн тохирсон “Ахан дүүгийн холбоотны гэрээ”-г албан ёсоор баталгаажуулах арга зам нь байлаа.²⁰

“Гориө са”-д Монголын элч Солонгосын хаантай хийсэн уулзалт, тэр уулзалтан дээр болсон хөгтэй гэмээр явдлыг тодорхой өгүүлдэг.

“Хачин Пулитайе-г хэдэн хүний хамт албан бичиг өгүүлэхээр илгээсэн юм. Тэд энхийн тухай хэлэлцэхээр эрэлхийлэн ирсэн болой. Хаан Паг Шиюнь түшмэлийг тэднийг (монголчуудыг) угтуулахаар илгээгээд иргэний болоод цэргийн түшмэдийг малгай өмсөн бүсээ зүүн Сүний Хаалганаас эхлэн баруун зүүн талаар тусдаа зогсох зарлиг буулгав. Пулитайван бусдынхаа хамт буудлын гадаа хүрч ирэн алхаагаа удаашруулаад зогсон (мориносоо буусангүй) буудал руу орсонгүй. Тэд хэлэхдээ: “Танай хаан гарч ирээд бидэнтэй мэндлэн угтах ёстой” гэлээ. Дараа нь хэлмэрчээр хоёр гурван удаа хүсэлтээ хэлүүлэв. Эцэст нь тэд нэг юм мориноосоо буугаад буудлын хаалгаар орсон юм”²¹. Хаанд бичгээ хэрхэн барисан тухай ч гарч байна.

“Хааныг морилон айлдахад монголчууд үстэй хувцас, малгай өмсөн, бөс бүслэн, нум, хормсоготой сумдаа агсацгаасан байсан бөгөөд чигээрээ өргөө рүү алхан очоод нэг нь өврөөсөө баримт бичиг гарган ирээд хааны гарыг шүүрч барьж аваад бичгээ атгуулчихав. Хааны царай хувирсан агаад тэнд байсан бараа бологчид бүгд цочирдоод хэн ч дөхөж зүрхэлсэнгүй. Хаанд бараа болж байсан түшмэл Чой Сөндань нулимс дуслуулан байж “Бид энэ хэдэн бүдүүлгүүдийг яаж дээд эзэндээ ойртуулан хүргүүлэв ээ? Тэд хааны маань аминд нь халдсан бол яах байсан юм бэ? Бид тэгсэн бол хааныгаа огт хамгаалж чадахгүй байх байлаа” гэжээ.” Тэрбээр Пулитайваныг гадагш авч гараад Солонгос хувцас өмсгөв. Тэд нарт улмаар сууц гарган өгөхөд зөвхөн гараа өргөн алга ташаад мэхийснээс өөр юм хэлсэнгүй. Тэдэнд зэрэг зиндаанд нь тааруулан алт мөнгөн сав суулга, торго, булганы арьс өгөв.”²²

Удалгүй монголчууд Солонгосоос гарч явжээ. Гарч явахдаа Хачин болоод тэдний төлөөлөгчид 41 даругачи хилийн хот Ыйжү-д үлдээн тэдэнд “Гориөгийн хэлийг сураад биднийг эргэн ирэхийг хүлээгтүн” гэсэн тушаал буулгажээ.²³ Ийнхүү монголчууд Гориөгоос алба авч байхаар болсон байна. Гэхдээ энэ албаа ямар хугацаатайгаар авч байсан нь сонирхол татна. Ерөөсөө Монголоос гадна Зүрчидүүд бас даарин дээр давс гэгчээр ирж алба шаарддаг байжээ. Мөн Монголчуудыг баруун зүгт аян дайн хийж явахад тэд Гориө рүү элчээ хэдэнтээ илгээн Монголын эсрэг эвсэл байгуулан дайтыя гэж хатган турхирч байсан нь “Гориө са”-д тэмдэглэгдэн үлдсэн байна. Тухайлбал “Гориө-

са"-гийн 22-р дэвтрийн "31а-б, 34 а-б" зэрэгт энэ талаар өгүүлж байна. Гориө улс энэ өөд Чингисийн отгон дүү Тэмүгэ Отчигиний мэдэлд байсан юм. Учир нь Манжуур, зүүн зүгийн нутаг ард түмнийг Чингис хаан отгон дүү Тэмүгэ Отчигиндоо соёрхсон байдаг.

Ийнхүү Гориөчүүд Монголд дагаар орсноо алба барих байдлаар илэрхийлж байсан юм. Монголчууд ч Гориөд олонтаа ирж байсан нь "Гориө-са"-д тодорхой буй. Тухайлбал 1221 онд л гэхэд 7, 8, 9, 10, 12 саруудад 3-23 хүний бүрэлдэхүүнтэй элч төлөөлөгчид Гориөд ирж байлаа. Дараах жилүүдэд ч цөөрсөнгүй. Гэтэл гэнэт харилцаа тасрав. Энэ явдал 1224 онд тохиожээ. 1224 оны намар Чу-ку-юү-гийн толгойлсон Монголын элч нар жил тутмын албаа шалгахаар ирээд "1225 оны 1-р сард Монголын элч нар Баруун нийслэлээс хөдөлж Ялу мөрнийг гаталжээ. Төрийн бэлгээс тэд гагцхүү халиуны арьсыг авч яваад торго зэрэг бусдыг нь орхижээ. Замдаа тэд дээрэмчдэд хороогдсон юм. Монголчууд биднийг үүнд сэрдэв. Түүнээс болоод харилцаа хүйтэрсэн болой"²⁴ Ийнхүү 1225 оны эхэн үеэс Монгол Гориөгийн харилцаа тасарсан байна.

Энэ үед Монголд ч олон том үйл явдал өрнөсөн билээ. 1227 онд Тангуд улсыг дайлж яваад Чингис хаан тэнгэрт хальж, Их Хурилдай-гаар 1229 онд өгөөдэй хаанд суусан. Тиймээс Солонгост анхаарал тавих нь хэсэгтээ алдарсан байсан бололтой. Зүрчидүүд Монголын хүчирхэгжилтэд огтхон ч хүсэхгүй байсан агаад удалгүй монголчууд тэднийг урваж тэрслэн босоход Манжуур орж Зүрчидийн Пүшиэнь Ванну-гийн командалсан армийг умар тийш Бэгтүсан нуруу руу шахаж, өмнө талаас нь Гориө улс Зүрчидийг шахан цохихыг хэлүүлсэн боловч Гориөчүүд хөдөлсөнгүй. Монголчууд дайсных нь эсрэг хамтран хөдлөөгүй улсыг эргэж заавал дайлан бүрмөсөн захиргаандаа оруултлаа дайтдаг уламжлалтай байсан. Гориөчүүд Зүрчидүүдтэй дайтаагүй нь өөрсөддөө аюул дуудсан хэрэг болсон агаад 1231 оны өвөл өрлөг жанжин Сартагийн командалсан Монголын цэргийн томоохон хүчин Ялу мөрнийг гатлан Гориө довтлон орж ирээд бүрмөсөн дагаар орохыг шаардсан ч солонгосчууд цааргалав. Ийнхүү 30 гаруй жил үргэлжилсэн Монголын удаа дараагийн аян дайнууд эхэлсэн билээ.

Ашигласан материал:

1. Don Oberdorfer. *The Two Koreans. A Contemporary History*. Basic Books. 1997. p-3
2. Мөн ном
3. И Пиёндэ: "Гүгса да-гуань", Сөүл. Хоёрдахь хэвлэл., 1958, ху-169
4. W.E. Henthorn: *Korea, The Mongol Invasion* Leiden E. J. Brill. 1963. p. 1.
5. "Хангүг-ый Сэнхуалса Банмүлгуань" Солонгосын амьдралын түүхийн музей. Сөүл. Сагиежол хэвлэлийн газар. 2003 он. 8-р боть. 84-р тал.

6. Carter J. Eckert, Ki-baik Lee, Young Ick Lew, Michael Robinson, Edward W. Wagner. Korea Old and New. A History. Korea Institute. Harvard University. 1990. p-91. Харин АНУ-ын түүхч Томас Оллсэн: "өгөөдэй хааны хүү, түүнийг залгамжлагч Гүюугийн (1246-48) дор эзэнт гүрний хан хөвгүүдийн сөргөлдөөний улмаас тэлэлт удаашрав. Гүюу нас барснаар энэ сөргөлдөөн, хуваагдал илэрхий тод болсон ба ихээхэн маргаантай залгамжлалаар Чингис хааны отгон хүү Толуйн хүү Мөнх (1251-59) хаган болсон юм. Сөргөлдөөнийг намжаах, Монголын эрчим хүчийг гадагш хандуулах үүднээс Мөнх хаан Солонгос, өмнөд Сүн болон Аббасидийн калифатын эсрэг томоохон цар хүрээтэй цуврал аян дайн эхлүүлсэн." гэж дүгнэсэн. (Thomas T. Allsen "Culture and Conquest in Mongol Eurasia", Cambridge University Press. 2004. p-17.)

7. ГС 21.25b

8. ЮГХТ1a

9. ГС 103.46

10. Монгол-Горио-ый хивонжсье мэн-яг-ый сөнгиөг. Бэгсань хагбо. Жье 6 хо. 1969. 06. ху-601. Сөүл 1999 оны дахин хэвлэлээс үзнэ үү.

11. ГС 103. 46

12. ГС 102. 76-8a

13. ГС 102. 76-8a

14. ЮШ 208. 26

15. ГС 103. 18a-19a

16. ГС. 103. 19a

17. ГС 103

18. ЮКЖШ. 2a

19. ЮГЖШ. 2a, ЮШ 208, 2a

20. W.E.Henthorn. p-20

21. ГС. 22. 166

22. ГС. 22. 166-17a

23. ГС 22. 17a

24. ГС. 22. 27a